

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2025.02.05

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүдэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэлээр Боловсролын салбарын хүрээнд гарсан шийдвэр, зүйл, заалтыг хяналтад авч, 2025 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, нийтлэг журам”-ыг тус тус удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хяналтад авсан дараах 6 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 15 заалтын 14 нь бүрэн биелэгдсэн буюу 100 хувийн үнэлгээтэй, 1 хэрэгжих шат байгаа буюу 50 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн ба биелэлтийг 99.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

- Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн 1 заалт
- Ерөнхийлөгчийн зарлиг 2 тогтоолын 2 заалт
- Улсын Их Хурлын 1 тогтоолын 2 заалт
- Улсын Их Хурлын байнгын хорооны 4 тогтоолын 7 заалт
- Засгийн газрын 3 тогтоолын 3 заалт
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 1 заалт

№	Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	Биелэлтийн дүн /хувь/
			100%	50%	0%			
1	Монгол улсын хууль /Төсвийн хэмнэлтийн тухай хууль/	1	1					100
2	Ерөнхийлөгчийн зарлиг	2	2					100

3	МУ-ын Их хурлын тогтоол	2	1					100
4	МУ-ын Их хурлын байнгын хорооны тогтоол	7	6	1				96.1
5	Засгийн газрын тогтоол	3	3					100
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	1	1					100
	БҮГД	16	15	1				99.7

- Боловсролын орчны аюулгүй байдлыг хангах хүрээнд аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 27 сургууль, 16 дотуур байрыг эрсдэлийн үнэлгээнд бүрэн хамруулсан байна. Хэдийгээр барилга ашиглалтын шаардлага хангахгүй 21 байгууламж байгаа ч 2025 онд тэдгээрийн 19.0 хувьд нь засвар хийж, үлдсэн хэсгийг 2026 оны улсын төсөвт тусгуулахаар шийдвэрлэжээ. Мөн цахим сургалтын дэд бүтцийг сайжруулах зорилтын хүрээнд төрийн өмчийн 23 сургууль шилэн кабелийн өндөр хурдны интернэтэд бүрэн холбогдож, техникийн суурь нөхцөл бүрдсэн байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг дэмжих чиглэлээр бодит ахиц гарсан бөгөөд нийт 226 багш, ажилтныг брайл үсэг болон тусгай арга зүйн сургалтад хамруулан чадавхжуулжээ. Сургуулиудын 96.2 хувь нь налуу шаттай болж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй 280 гаруй ажилтанд 22.1 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон нь удирдлагын үр дүнтэй зохион байгуулалт болсон гэж үзэж байна. Үүнээс гадна сургуулийн хоол үйлдвэрлэлийн орчинг сайжруулахад олон улсын байгууллагын дэмжлэгийг авч, хангалтын түвшинг 88.6 хувьд хүргэсэн байна.
- Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зарлигийн дагуу 586 багш, ажилтныг сургалтад хамруулж, 60 байгууллага гаднах хаягаа стандартын дагуу хос бичгээр шинэчлэн байршуулжээ.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд үрэлгэн зардлыг хязгаарлаж, багш нарын мэргэжил дээшлүүлэх 25 удаагийн сургалт болон 37 удаагийн уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн байна.
- Хяналт-шинжилгээгээр илэрсэн гол дутагдал нь УИХ-ын Байнгын хорооны 2021 оны 8 дугаар тогтоолоор батлагдсан “Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” заалтын биелэлт юм. Тодруулбал, Баян-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн хоёр салбар бүлэг болон ерөнхий боловсролын бага сургуулийн ариун цэврийн байгууламж барих ажлын гүйцэтгэл одоогоор 60 хувьтай байна. Уг ажил удаашралтай байгаа нь зураг төсвийн компанитай холбоотой асуудлаас үүдэлтэй бөгөөд одоогийн байдлаар гэрээ цуцлах санал хүргүүлээд байгаа тул хэрэгжилтийн явцыг 50 хувьтай буюу "хэрэгжих шатанд" гэж үнэлэх үндэслэл боллоо. Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн тайланд хийсэн хяналт-шинжилгээний үр

дүнг нэгтгэн дүгнэвэл, хууль тогтоомж болон тогтоол шийдвэрийн хэрэгжилт ерөнхийдөө өндөр үзүүлэлттэй байна. Нийт авч үзсэн 11 үндсэн заалтын 10 нь буюу дийлэнх хувь нь 100 хувийн биелэлттэй байгаа бол үлдсэн нэг заалт нь 50 хувийн буюу хэрэгжих шатандаа үнэлэгджээ.

ДҮГНЭЛТ:

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэвэл, боловсролын салбарын хөрөнгө оруулалт болон дэд бүтцийг сайжруулах чиглэлээрх ажлууд ерөнхийдөө өндөр гүйцэтгэлтэй байна. Тухайлбал, аймгийн хэмжээний төрийн өмчийн 23 сургууль өндөр хурдны шилэн кабелийн интернэтэд бүрэн холбогдож, сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн орчинг сайжруулах ажил 88.6 хувьд хүрч, төлөвлөсөн ажлууд 100 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эрхийг хангах, тэднийг дэмжих төвийг ажиллуулах болон багш, ажилтнуудыг чадавхжуулах сургалт, урамшуулал олгох үйл ажиллагаанууд бүрэн биелсэн байна.

Цаашид Баян-Уул сумын барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор БЕГ, БХТ-тэй хамтран гүйцэтгэгчийн асуудлыг шуурхай шийдвэрлэж, хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Мөн мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр засвар үйлчилгээ хийх шаардлагатай гэж тодорхойлогдсон сургууль, цэцэрлэг, дотуур байрны 28.6 хувьд 2026 онд хөрөнгө оруулалт хийхээр улсын төсөвт тусгагдсан тул эдгээр ажлын бэлтгэлийг хангах нь зүйтэй.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ХАРИУЦСАН АХЛАХ АРГА ЗҮЙЧ



ҮНЭЛГЭЭ
А.МӨНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН: ДАРГА

Ч. АРИУНАА